



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 21 оны 05 дугаар
сарын 18 -ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолын 5.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, хариуцагч болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудад даалгасугай.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллага, салбар дундын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангаж, хяналт тавин биелэлтийг 2 жил тутам танилцуулж байхыг Онцгой байдлын ерөнхий газар (хошууч генерал Г.Ариунбуян)-т үүрэг болгосугай.

Монгол Улсын Шадар сайд



С.АМАРСАЙХАН

0021100207

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны
05 дугаар сарын 05-ны өдрийн 57 дугаар
тушаалын хавсралт

“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ II ҮЕ ШАТ (2021-2025)-НЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Стратегийн зорилго	Гамшгийн аюул, өртөх байдал, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)	-Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, удирдлагын тогтолцоо боловсронгуй болж, хүч хэрэгслийн чадавх дээшилсэн байна. -Гамшгийн эрсдэлийг үнэлэх тогтолцоо бэхжиж, гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан хөгжүүлсэн байна. -Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 70 хувьд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн байна. -Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах олон нийтийн мэдлэг ойлголт, оролцоо нэмэгдсэн байна. -Монгол Улсын гамшгийн нөхцөл байдлын тайланг жил бүр гаргаж олон нийтэд хүргэсэн байна.
Үйл ажиллагааны чиглэл	Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх

Д/д	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Үр дүнгийн болон чанарын шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Тэргүүлэх чиглэл 1. Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох						
Зорилт 1.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх						
1.1.1.	Гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголт, чадвар, дадал болон нийгмийн эрүүл мэндийн боловсролыг хүүхэд, залууст боловсролын байгууллагаар дамжуулан олгох	Сургалт, хичээлээс гадуурх хөтөлбөр	-Их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, хичээлээс гадуурх ажлын хөтөлбөрт тусгасан байх -дадлагад суурилсан байх	БШУЯ	ЭМЯ, ХНХЯ, ОБЕГ, ТББ, ОУБ	2021-2025

1.1.2.	Иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийг байгуулах, шинээр тохижуулах	Иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын төвүүд	-3-аас доошгүй аймагт иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийг бий болгосон байх -сургалт явуулах орчин бүрдсэн байх	ОБЕГ	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, ОУБ	2021-2025
1.1.3.	НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын "Сургууль, цэцэрлэгийн цогц аюулгүй байдал" санаачилгыг дэмжиж, үйл ажиллагааг өргөжүүлэх	Сургалт дадлага; гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ	-Ерөнхий боловсролын сургуулийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх -ЕБС, цэцэрлэгийн 70 хувьд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн байх	БШУЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗД	ОБЕГ, ГХУА, ТББ, ОУБ	2021-2025
1.1.4.	Гамшгаас хамгаалах сургалтыг, бүх түвшинд зохион байгуулах	Сургалт, дадлага	-Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан ангиллаар жил бүр зохион байгуулсан байх, -Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургалтыг жилд 2-3 аймагт зохион байгуулж, холбогдох байгууллага, иргэдийн оролцоог хангасан байх -гамшгаас хамгаалах мэдлэг ойлголт сайжирсан байх -гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдсэн байх	ОБЕГ	ГХУА, Аймагийн ЗД, ОУБ	2021-2025
1.1.5.	Гамшгийн үед эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах	Эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан	-коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх үйл ажиллагаанд суурилсан нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед	ЭМЯ	УОК, ОБЕГ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗД,	2021-2023

		сургалт	ажиллах, ажиллагаа зохион байгуулах тухай сургалтын цогц материал бэлтгэх, сургалтад ашиглах -сургалтад эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагчийн тэгш оролцоог хангах (удирдлага, эмч, сувилагч, жолооч)		ОУБ	
1.1.6.	Монгол Улсын гамшгийн нөхцөл байдлын тайланг жил бүр гаргаж олон нийтэд хүргэх	Монгол Улсын гамшгийн нөхцөл байдлын тайлан /Цагаан ном/	-албан ёсны мэдээллийн эх сурвалж болох тайлан жил бүр гаргасан байх -холбогдох талуудын мэдээлэл бүрэн туссан, товч тодорхой байх	ОБЕГ	ГХУА, МУЗН, ТББ, ОУБ	2021-2025
1.1.7.	Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийг явцын тайланг боловсруулж, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газарт хүргүүлэх	Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлж буй арга хэмжээний цахим тайлан	-боломжит статистик мэдээлэлд суурилсан байх -холбогдох талуудын мэдээлэл багтсан байх	ОБЕГ	ГХУА	2021-2025
1.1.8.	Улсын хэмжээнд гал түймэр, геологи, биологи, уур амьсгал, ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаатай холбоотой ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр нэгдсэн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах	Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг	-улсын хэмжээнд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг салбар дундын болон олон улсын байгууллагын оролцоонд тулгуурлан жил бүр боловсруулах -гал түймэр, өвөлжилт, хаваржилт хүндрэхээс болон зудын аюул, шар ус, үер, усны осол, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан	ОБЕГ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ААНБ, ТББ, ОУБ	2021-2025

			<p>сэргийлэх, таниулах арга хэмжээнд оролцогчдын тоо нэмэгдсэн байх</p> <p>-Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг жил бүрийн 10 дугаар сарын 13, Олон улсын иргэний хамгаалалтын өдрийг жил бүрийн 03 дугаар сарын 01, Гамшгаас хамгаалах эрт зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийг жил бүрийн 03 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Пүрэв гаригт зохион байгуулсан байх</p> <p>-арга хэмжээ олон нийтэд чиглэсэн, олныг хамарсан байх</p> <p>-олон талт хамтын ажиллагаанд суурилсан байх</p>			
1.1.9.	<p>Гамшгийн эрсдэлийг бууруулахад эмэгтэйчүүдийн оролцоо, гамшгийн үеийн хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Бага хурал, форум, сургалт, нөлөөллийн арга хэмжээ</p>	<p>-Гамшгийн эрсдэлийг бууруулахад эмэгтэйчүүдийн оролцоо сэдвээр бага хурлыг 2 жилд тутам зохион байгуулах</p> <p>-Гамшгаас хамгаалах сургалтад эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн оролцоог хангасан байх</p> <p>-гамшгийн үеийн хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал,</p>	<p>ХНХЯ, Жендэрийн үндэсний хороо, ОБЕГ</p>	<p>Бүх яамд, Аймгийн ЗД, ТТБ, ОУБ,</p>	<p>2021-2025</p>

			жөндөрт суурилсан хүчирхийллийн эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн бусад арга хэмжээг жил бүр зохион байгуулсан байх			
Зорилт 1.2. Гамшгийн эрсдэлийг үнэлэх тогтолцоог бий болгож, мэдээллийн сан бүрдүүлэх						
1.2.1	Гамшгийн төрөл бүрээр улсын хэмжээний гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх	Улсын хэмжээний гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ	-гамшгийн 6-аас дээш төрлөөр хийх -улсын хэмжээний мэдээ, мэдээлэлд суурилах	Холбогдох бүх, яам, агентлаг, Аймаг, нийслэл дүүргийн ЗД	ТББ, ОУБ	2021-2022
1.2.2	Эрчим хүчний гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх	Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан	-төвийн эрчим хүчний системийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байх -үнэлгээнд суурилан гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох нөхцөлийг бүрдүүлсэн байх	ЭХЯ	ОБЕГ	2021-2022
1.2.3	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх	Газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ	-засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг нийт 4 аймагт хийх -талуудын оролцоог хангасан байх	ОБЕГ, Аймаг, нийслэл, дүүргийн онцгой байдлын газар, хэлтэс	Аймаг, нийслэлийн ЗД	2021-2025
1.2.4	Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний зохицуулалтыг боловсронгуй болгох	Шинэчлэгдсэн журам, заавар, шалгуур үзүүлэлт	-эрх зүйн зохицуулалт, өнөөгийн тулгамдаж буй асуудалд суурилан гамшгийн эрсдэлийн үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн	ОБЕГ	ШСАА, ГХУА	2021-2022

			ажиллах журам, гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар, гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд тавигдах шалгуур үзүүлэлтийг сайжруулсан байх			
1.2.5	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хүнс, хөдөө аж ахуйн салбарт учрах өөрчлөлтийг судлах, эрсдэлийн зураглал боловсруулах	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хүнс, хөдөө аж ахуйн салбарт гарч буй өөрчлөлтийг судлах, эрсдэлийн зураглал хийх	-уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хүнс, хөдөө аж ахуйн салбарт гарч буй өөрчлөлт, цаашдын хандлагын чиглэлээр судалгааны ажил хийх, -эрсдэлийн зураглал боловсруулах	БОАЖЯ ХХААХҮЯ	ОБЕГ, ТББ, ОУБ	2021-2025
1.2.6	Гамшгийн мэдээллийн нэгдсэн сан хөгжүүлэх	Гамшгийн мэдээллийн нэгдсэн сан	-гамшгийн хохирол, гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэдээллийн цахим сан нь олон нийтэд нээлттэй, хялбар ашиглагдахуйц байх -мэдээлэлд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, амьжиргааны түвшин зэрэг ангиллыг багтаасан байх	ГХУА, БХБЯ, ЭМЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, МХЕГ, БШУЯ, ОБЕГ	ҮСХ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ШУА, ТББ, ОУБ	2021-2025
1.2.7	Аймаг, сум, суурин газруудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт,	Газар хөдлөлтийн бичил мужлалын зураг, инженер геологийн зураглал, мэдээллийн	-21 аймгийн төв, Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил мужлалын зураг, инженер геологийн зураглалыг багтаасан байх -олон нийт хэрэглэх боломжтой байх	БХБЯ	СЯ	2021-2024

	техникийн судалгааны ажлын хийж дуусгах, мэдээллийн нэгдсэн санд оруулах.	нэгдсэн сан				
Тэргүүлэх чиглэл 2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх						
Зорилт 2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох						
2.1.1.	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн хуралдаан	-Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн хуралдааныг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах -зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэх	ОБЕГ, Аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	Аймаг, нийлэл дүүргийн онцгой байдлын газар, хэлтэс	2021-2025
2.1.2.	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд хөрөнгө оруулалт, санхүүжилтийг улсын хэмжээнд нэгтгэн бүртгэх тогтолцоог бий болгох	Зохицуулах баримт бичиг	-зохицуулах эрх зүйн баримт бичиг батлагдсан байх -судалгаанд үндэслэгдсэн байх	СЯ, ОБЕГ		2022-2025
2.1.3.	Соёлын өвийг гамшиг, аюулт үзэгдэл, ослоос хамгаалах чиглэлээр арга хэмжээ авах	Бодлогын баримт бичиг, соёлын өвийн барилгыг хүчитгэх	-соёлын өвийг гамшиг, аюулт үзэгдэл, ослоос хамгаалах чиглэлээр салбарын бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, шинээр тусгах -хүчитгэх шаардлатагтай соёлын өвийн барилгын жагсаалт гаргах, үе шаттай хүчитгэх арга хэмжээ авах	Соёлын яам, БХБЯ	ОБЕГ, Аймаг, нийслэлийн ЗД	2021-2024
Зорилт 2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулахад түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх						
2.2.1.	Гамшгийн эрсдэлийг бууруулахад оруулсан хөрөнгө оруулалтыг хөхиүлэн	Зохицуулах баримт бичиг	-зохицуулах эрх зүйн баримт бичиг батлагдсан байх -хувийн хэвшлийн гамшгийн	ОБЕГ	СЯ, Хувийн хэвшил	2022-2024

	дэмжих, урамшуулах зохицуулалт бий болгох		эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмжсэн байх.			
2.2.2	Гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн төр хувийн хэвшлийн түншлэл, дотоод, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хамтран ажиллаж буй байгууллагууд, гадаад улс орнууд	-санамж бичгийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хамтран ажиллах байгууллага, хувийн хэвшлийн тоо нэмэгдсэн байх -1-2 гадаад улс орон, олон улсын байгууллагатай шинээр хамтын ажиллагаа тогтоох -Төв болон Зүүн Өмнөд Ази дахь хамтын ажиллагааг бэхжүүлсэн байх	ОБЕГ	ГХЯ, ТББ, ААНБ, ОУБ	2021-2025
2.2.3	“Аюулгүй, гамшгийг даван туулах чадавхтай хот” олон улсын санаачлагад нэгдэн орсон нийслэл хот, аймгийн төвийн үйл ажиллагааг дэмжих	Үнэлгээ, төлөвлөлт хийх сургалт, ололт амжилт, туршлагыг түгээн дэлгэрүүлэх	-хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх -санаачилгад нэгдэн орсон нийслэл хот, аймгуудын гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр олон ололт амжилт, туршлагын Монгол Улс болон олон улсад түгээн дэлгэрүүлэх -хот суурин газрын хөгжлийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн байх	Аймаг, нийслэлийн ЗД	ОБЕГ, ОУБ	2021-2025
Зорилт 2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үндэсний стандартыг боловсронгуй болгох						
2.3.1.	Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын стандартыг боловсруулж батлуулах	Батлагдсан стандарт	-гамшгийн үеийн хүүхэд хамгааллын стандартыг батлуулсан байх -олон улсын стандарт	ХНХЯ, ОБЕГ	БШУЯ	2021-2025

			жишигт нийцсэн байх			
2.3.2.	Гамшгийн шуурхай удирдлага, холбоо, зарлан мэдээллийн системд тавих ерөнхий шаардлага, зарлан мэдээллийн техник хэрэгслийн ангилал, тэдгээрт тавигдах шаардлагыг тогтоосон стандарт гаргах	Батлагдсан стандарт	-стандартыг боловсруулсан байх -олон улсын стандарт жишигт нийцсэн байх	ОБЕГ, СХГ	Аймаг, нийлэл дүүргийн онцгой байдлын газар, хэлтэс	2021-2025
Тэргүүлэх чиглэл 3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх						
Зорилт 3.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх						
3.1.1.	Барилга байгууламжийн хийц, бүтээц, материал, түүхий эдийн чанарыг тодорхойлж, туршилт, шинжилгээ, судалгаа гаргах нэгдсэн лаборатори байгуулах	Туршилт, шинжилгээ, судалгааны лаборатори	-барилгын материалын туршилт, судалгааны нэгдсэн лаборатор байгуулсан байх -орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, эрэлт хэрэгцээг хангасан байх	БХБЯ	СЯ	2021-2025
3.1.2.	Хот, суурин газрын үерийн хамгаалалт, далан суваг, инженерийн байгууламжийг сайжруулах, нэмэгдүүлэх	Үерийн хамгаалалт, далан суваг, инженерийн байгууламж	-аймаг, нийслэл тус бүр үе шаттай сайжруулалт хийсэн байх -үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх	БХБЯ, Аймаг, нийслэлийн ЗД	СЯ	2021-2025
3.1.3.	Үерийн гамшигт тэсвэргүй авто зам, төмөр замын суурь дэд бүтцэд хийх хүчитгэл, шинэчлэлийн ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг үе шаттай зохион байгуулах.	Авто зам, төмөр замын суурь дэд бүтцэд хийх хүчитгэл, шинэчлэл	-улсын чанартай авто зам, төмөр замын суурь дэд бүтцэд хүчитгэл, шинэчлэл хийх ажил үе шаттай зохион байгуулагдсан байх -гамшгийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан байх	ЗТХЯ	СЯ	2021-2025
3.1.4.	Гамшгийн шалтгаан, нөхцөл, галын аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох	Лабораторийн тоног төхөөрөмж,	-орчин үеийн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй болсон байх	ОБЕГ	СЯ, БХБЯ, ОУБ	2022-2025

	лабораториудын хүчин чадлыг сайжруулж орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, аргазүй, аргачлал нэвтрүүлэх	багаж хэрэгсэл, аргачлал	-туршилт шинжилгээний шинэ арга, аргачлалыг нэвтрүүлсэн байх			
3.1.5.	Гамшгийн эрсдэлийг бууруулахад эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх	Гамшгийн эрсдэлийг бууруулах судалгааны тайлан, шинэ техник, технологийн хэрэглээ	-эрдэм шинжилгээ, судалгааны ажлын цар хүрээ өргөжсөн байх -дэвшилтэт технологи, инновац нэвтэрч, бүтээмж нэмэгдсэн байх	ОБЕГ	ОУБ, ШУА-ын салбар хүрээлэн, Их, дээд сургууль, ААНБ	2021-2025
3.1.6.	Төв суурин газрын хүн амыг үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нэн шаардлагатай доплерийн радарын сүлжээг байгуулах	Үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх доплерийн радарын сүлжээ	-доплерийн радарын сүлжээг байгуулсан байх -үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлсэн байх	БОАЖЯ, Нийслэлийн ЗД	ОБЕГ, ОУБ	2021-2025
Зорилт 3.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх						
3.2.1.	Аймаг, нийслэл, сум, дүүрэгт гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	-гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хөрөнгө оруулалт нэмэгдсэн байх -жил бүрийн төсөвт тусгаж батлуулсан байх	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД	СЯ, ОБЕГ	2018-2020
3.2.2.	Гамшгийн үед эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн бэлэн байдал (эмнэлгийн барилга байгууламж, хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, зөөлөн болон хатуу эдлэл, цэвэр ус, цахилгааны	Эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдлын судалгаа Нөөцийн бэлэн байдал	-эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн бэлэн байдал дээшилсэн байх -хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтрах	ЭМЯ	СЯ	2021-2025

	найдвартай эх үүсвэр гэх мэт)-ыг ханган ажиллах, нөөцийн бэлэн байдалд байнгын тодотгол хийх, хяналт тавих	нэмэгдсэн байх				
3.2.3.	Гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгал, давхар даатгалын тогтолцоог бий болгох нөхцөлийг бүрдүүлэх	Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хуулийн төсөл	-гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын тухай хуулийн төсөл боловсруулахад шаардагдах судалгаа явуулах, хуулийн төслийг боловсруулсан байх -бусад хууль тогтоомжтой нийцсэн, нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхүйц байх	СЯ, ОБЕГ	ТББ, ААНБ	2021-2023
Тэргүүлэх чиглэл 4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх						
Зорилт 4.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлж, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх						
4.1.1.	Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх	Хүний нөөцийн чадавх	-алба хаагчдыг мэргэжлийн боловсрол олгох, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох -сургалтад хамрагдах албан хаагчийн тоо 2020 онтой харьцуулахад нэмэгдсэн байх -аврагчийг төрөл мэргэжлээр мэргэшүүлж, ахлагч бүрэлдэхүүний ур чадварыг нэмэгдүүлсэн байх	ОБЕГ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ОУБ	2021-2025

4.1.2.	Гамшгаас хамгаалах, гал түймэр унтраах сайн дурын үйл ажиллагааны тогтолцоог сайжруулах, чадавхыг нэмэгдүүлэх	Шинэчилсэн эрх зүйн баримт бичиг, сургалт, нөлөөллийн арга хэмжээ	-холбогдох эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах -сайн дурынханд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургаж бэлтгэх -орон нутгийн сайн дурын хэсгийн хувцас хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг сайжруулсан байх -сайн дурын үйл ажиллагааг сурталчлах	ОБЕГ Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД,	Хувийн хэвшил, ТББ, ОУБ	2021-2025
4.1.3.	Агаараас эрэн хайх аврах ажиллагаа явуулах нэгжийг байгуулах, нисдэг тэрэг нийлүүлж чадавхыг нэмэгдүүлэх	Нисэх нэгж, нисдэг тэрэг	-олон улсын стандарт, Монгол Улсын холбогдох хууль, дүрмийн дагуу нисэх нэгжийг байгуулах, бэхжүүлэх -хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу нисдэг тэрэг нийлүүлэгдсэн байх -алба хаагчийг сургаж бэлтгэсэн байх	СЯ, ОБЕГ	ГЕГ, ОУБ	2021-2025
4.1.4.	Гал түймэр унтраах, эрэн хайх, аврах ажиллагааны хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх	Тусгай зориулалтын автомашин	-гал унтраах, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгсэл нийлүүлэгдсэн байх -алба хаагчийг сургаж бэлтгэсэн байх	СЯ, ОБЕГ	ГЕГ, ОУБ	2021-2022
4.1.5.	Монгол Улсад гамшгийн аюулын зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бий болгох	Зарлан мэдээлэл дамжуулах техник хэрэгсэл	-зарлан мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, техникийн шаардлагыг журамласан эрх зүйн баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулах -улсын хэмжээнд зарлан	ХХМТГ, ОБЕГ, ООГФХ	СЯ, ОУБ	2021-2025

			мэдээлэл дамжуулах техник хэрэгслийн хүртээмж нэмэгдсэн байх			
4.1.6.	Гамшгийн үед ашиглах радио холбооны сүлжээ болон хөдөлгөөнт төвүүдийг өргөтгөн сайжруулах	Радио холбооны үндсэн болон дамжуулах сүлжээ	-холбоо, зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын 2 төвийг байгуулсан байх -ажиллах хүчин сургаж бэлтгэгдэн байх	ХХМТГ, ОБЕГ	СЯ	2021-2025
4.1.7.	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах чиглэлээр "Хээрийн хөдөлгөөнт эмнэлэг"-ийг дадлага сургуульд ашиглах	"Хээрийн хөдөлгөөнт эмнэлэг" дэлгэсэн дадлага сургууль	-төв, орон нутагт гамшгаас хамгаалах дадлага сургуульд "Хээрийн хөдөлгөөнт эмнэлэг" иж бүрнээр дэлгэсэн байх -төрийн цэргийн байгууллагуудын хээрийн хөдөлгөөнт эмнэлгийн нэгдсэн дадлага, сургуулийг зохион байгуулах	БХЯ, ОБЕГ	Аймаг, нийслэл, дүүргийн ЗД	2021-2023
4.1.8.	Томилгоот гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах	Сургууль дадлага, бэлэн байдлын үзлэг	-жилд 1-2 гамшгаас хамгаалах улсын албаны Команд штабын сургалт зохион байгуулсан байх -жилд 2-оос доошгүй аймаг, дүүрэгт гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан байх -гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, холбогдох байгууллагыг хамруулсан байх	ГХУА, ОБЕГ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ, ГХУА	2021-2025
4.1.9.	Гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настныг аврах ажиллагааны чиглэлээр аврагчдад сургалт,	Сургалт, дадлага	-аврагчид хөдөлгөөний болон харааны хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настныг аврах чиглэлээр	ХНХЯ, ОБЕГ	ТББ, ОУБ	2022-2024

	дадлага зохион байгуулах		сургалт, дадлага зохион байгуулах -аврагчдын 60-аас доошгүй хувийг хамруулан мэдлэг, чадвар олгосон байх			
4.1.10	Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд гамшгийн шуурхай удирдлагын нэгдсэн төв (хямралын удирдлагын нэгдсэн төв) байгуулах боломжийг судлах	Гамшгийн шуурхай удирдлагын нэгдсэн төвийн техник, эдийн засгийн үндэслэл	-нэгдсэн төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах -бүх гамшгийн төрлийн үед ашиглагдахад чиглэсэн байх	ОБЕГ	СЯ	2022-2024
4.1.11	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилгоор бэлчээрийн менежментийг сайжруулах, шар усны үер, ган, зудын эрсдэлээс эрт сэрэмжлүүлэх, эрт хариу арга хэмжээг авах	Судалгаа, төсөл хөтөлбөр	-уур амьсгалын өөрчлөлтийн төлөв, цаг агаарын урьдчилсан мэдээ, таамаглалыг талуудад хүртээмжтэй түгээх -салбар дундын оролцоонд тулгуурлан урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх -орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх	БОАЖЯ, ХХААХҮЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗД	ОБЕГ, ТББ, ОУБ	2021-2025
4.1.12	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандан судалгааны ажлыг өргөжүүлэх	Судалгаа	-судалгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх	ХХААХҮЯ, МЭЕГ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗД	ОБЕГ	2021-2025
4.1.13	Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой байлгах зорилгоор мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг	Төсөл хөтөлбөр	-мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдэд дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх -мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл	ХХААХҮЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗД	СЯ, ОУБ	2021-2025

	нэмэгдүүлэхэд дэмжих үзүүлэх		өссөн байх -гамшгийн үед хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн нөөцийг хангахад чиглэсэн байх			
4.1.14	Монгол Улсын эрэн хайх, аврах багийг НҮБ-ын Эрэн хайх, аврах олон улсын зөвлөлдөх бүлгийн дунд түвшний ангилал авахад бэлтгэх	Олон улсад ажиллах чадвартай хот дахь эрэн хайх, аврах баг	-олон улсад ажиллах чадвартай эрэн хайх, аврах баг бэлтгэх -хот дахь эрэн хайх, аврах олон улсын дасгал сургуулийг Монгол Улсад зохион байгуулах асуудлыг НҮБ-д тавих	ОБЕГ	ГХЯ, ТТБ, ОУБ	2021-2025
4.1.15	Онцгой байдлын байгууллагын бүсийн тогтолцоонд суурилан техник хэрэгслийн засвар үйлчилгээний хөдөлгөөнт болон суурин цэгүүдийг бий болгох	Хөдөлгөөнт болон суурин цэг	-1-2 хөдөлгөөнт болон суурин цэг байгуулсан байх -судалгаанд суурилсан байх	ОБЕГ	СЯ	2021-2025
4.1.16	Нүүлгэн шилжүүлэх түр байрыг стандартын дагуу байгуулах, ашиглах журам боловсруулах	Журам	-холбогдох стандартад суурилсан байх -аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд хөрөнгө, санхүүг шийдвэрлэхээр тусгасан байх	ОБЕГ	Аймаг, нийслэл, дүүргийн ЗД	2022-2023
4.1.17	Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг сайжруулах	Гамшгаас хамгаалах улсын хяналт	-Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гамшгаас хамгаалах улсын хяналтын нэгж байгуулах, орон тооны гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийг Баян-Өлгий, Баянхонгор, Булган,	ОБЕГ	СЯ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД	2021-2023

			Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан аймаг болон нийслэлийн дүүргүүдэд томилогдсон байх -гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт 2020 оны түвшнээс нэмэгдсэн байх			
4.1.18	Улаанбаатар хотод гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед Түлш эрчим хүчний улсын албаны штабын гишүүд болон Улаанбаатар хот дахь эрчим хүчний үйлдвэр, компаниудын удирдлага, диспечер-инженерүүдийн ашиглах нөөц холбооны хэрэгслийг бүрдүүлэх.	Иж бүрэн холбооны хэрэгсэл	-Улаанбаатар хотын аль ч цэгээс холбогдох холбооны хэрэгслийг бүрдүүлсэн байх	ЭХЯ	ХХМТГ, ХХЗХ	2021-2023
Зорилт 4.2. Гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг сайжруулах						
4.2.1.	Нийслэлийн хүн амын улирлын чанартай хүнсний бүтээгдэхүүний үнэ, хангамжийг тогтвортой байлгах зорилгоор зорь, агуулахыг нэмэгдүүлэх	Хөргүүр бүхий автоматжуулсан махны зорь, хүнсний агуулах	-стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэж, бараа, материалын хадгалалт, хамгаалалт сайжирсан байх -дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн агуулахын хүчин чадал нэмэгдсэн байх	ОБЕГ	СЯ, ХХААХҮЯ	2021-2024
4.2.2.	"Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын	Газрын тосны бүтээгдэхүүний агуулах	-стратегийн зориулалттай 20,0 мян.м3-ын багтаамжтай газрын тосны бүтээгдэхүүний	ОБЕГ	СЯ, УУХҮЯ	2021-2024

	цогцолбор байгуулах” төсөл хэрэгжүүлэх		агуулах баригдсан байх -бараа, материалын хадгалалт, хамгаалалт сайжирсан байх -дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн агуулахын хүчин чадал нэмэгдсэн байх			
4.2.3.	Гамшгийн дараах хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх	Аргачилсан заавар	-гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний аргачилсан заавар боловсруулсан байх -үнэлгээ хийх хүний нөөцийг бэлтгэгдсэн байх	ГХУА, ОБЕГ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ТББ, ОУБ	2022-2024
4.2.4.	Газар хөдлөлтөд тэсвэргүй, барилга, байгууламжийг хүчитгэх, ашиглалтын шаардлага хангахгүй тохиолдолд буулгах, шинээр барих үйл ажиллагааг зохион байгуулах	Газар хөдлөлтөд тэсвэртэй барилга, байгууламж	-үнэлгээнд суурилан хүчитгэх, шинээр барих барилгын жагсаалтыг шинэчлэн гаргах -гамшигт тэсвэржилтийг сайжруулах, загвар зураг, төсөл боловсруулсан байх -үе шаттайгаар шинэчлэн сайжруулж барьсан байх -газар хөдлөлт, гамшгийн аюулд тэсвэртэй, стандарт шаардлагыг хангасан байх	БХБЯ ГХЭББАЗ, МХЕГ	СЯ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ОУБ	2021-2025
4.2.5.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулах	Агуулах	-стандартад нийцсэн агуулах баригдсан байх	ЭМЯ	СЯ	2021-2024

ТОВЧИЛСОН НЭР:

Яамд:

БОАЖЯ
БШУЯ

Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Боловсрол, шинжлэх ухааны яам

БХБЯ
БХЯ
ГХЯ
ЗТХЯ
СЯ
УУХҮЯ

Барилга, хот байгуулалтын яам
Батлан хамгаалах яам
Гадаад харилцааны яам
Зам, тээврийн хөгжлийн яам
Сангийн яам
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ХНХЯ
ХЗДХЯ
ХХААХҮЯ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Хууль зүй, дотоод хэргийн яам
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

ЭМЯ
ЭХЯ
ГХЭББАЗ

Эрүүл мэндийн яам
Эрчим хүчний яам
Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах байнгын ажиллагаатай зөвлөл

ШСАА

Шадар сайдын ажлын алба

Засгийн газрын агентлаг, бусад байгууллага:

ААНБ Аж ахуйн нэгж байгууллага
АМГТГ Ашигт малтмал, газрын тосны газар

ГЕГ Гаалийн ерөнхий газар
ГХУА Гамшгаас хамгаалах улсын алба
ЗДТГ Засаг даргын тамгын газар
МХЕГ Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУЗН Монголын улаан загалмай нийгэмлэг
МҮХАҮТ Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн тэнхим
МЭЕГ Мал эмнэлгийн ерөнхий газар
ОБЕГ Онцгой байдлын ерөнхий газар
ООГФХ Одон орон, геофизикийн хүрээлэн
СХЗГ Стандарт, хэмжил зүйн газар
УОК Улсын онцгой комисс
ҮСХ Үндэсний статистикийн хороо
ХСИС Хууль сахиулахын их сургууль
ХХМТГ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ХХЗХ Харилцаа холбооны зохицуулах хороо
ШУА Шинжлэх ухааны академи
ОУБ Олон улсын байгууллага
ТББ Төрийн бус байгууллага